


**УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ**

ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ

Улаанбаатар
2023 он

Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын
ажиллагааны төвийн захирлын Д.Д.Д оны Ц сарын
22-ны өдрийн 1/10 тушаалын 2-р хавсралт



**“УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН СУДАЛГАА,
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТӨВ”-ИЙН
ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ**

1. Нийтлэг үндэслэл

- 1.1 “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв” ХХК (цаашид “Төв” эсхүл “Ажил олгогч” гэх)-ийн Хөдөлмөрийн дотоод журам нь Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль, Байгаль Орчныг хамгаалах тухай хууль, Монгол Улсын нэгдэн олон улсын гэрээ болон Төвийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга, дэг журмыг хангах, ажлын зохион байгуулалт, цаг ашиглалтыг сайжруулах, ажлын үр дүн чанарыг хангах, Төв болон ажиллагсдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүссэн хөдөлмөрийн харилцааг зохицуулах баримт бичиг юм.
- 1.2 Ажил олгогч нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан эрхийн хүрээнд энэхүү дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлнэ.
- 1.3 Хөдөлмөрийн сахилгыг сахин биелүүлж, энэхүү дотоод журмыг мөрдлөг болгон үнэнч шударга, үр бүтээлтэй хөдөлмөрлөх, холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүргээ биелүүлэх нь ажилтан бүрийн үүрэг мөн.
- 1.4 Хөдөлмөрийн дотоод журмыг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа асуудлыг Төв өөрийн дүрэм болон энэ журмыг үндэслэн шийдвэрлэх ба энэхүү журмын биелэлтэд Төвийн удирдлага, зохих ажилтнуудын хамт байнгын хяналт тавьж ажиллана. Дотоод журмыг шинээр ажилд орж буй ажилтанд ажлаа эхлэхээс нь өмнө, дотоод журам шинэчлэгдэх, өөрчлөгдөх бүрд бүх ажилтнуудад танилцуулж, цаашид жилд нэг удаа Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан сургалт зохион байгуулна.
- 1.5 Төвийн ажлын зорилго, ажлын гүйцэтгэл, өмч хөрөнгийн зарцуулалт, хөдөлмөрийн сахилга, дэг журам болон тэдгээртэй холбоотой цаг үеийн үйл ажиллагааны талаар Захирлын дэргэдэх хэлтсүүд ажиллана. Удирдлагын баг хэлэлцсэн асуудлын талаар зөвлөмж гаргах бөгөөд шаардлагатай асуудлаар эцсийн шийдвэрийг Захирал гаргана.
- 1.6 Төв нь зохих тамга, тэмдэг, өөрийн бэлгэдэл, албан хэргийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд удирдлагаас итгэмжлэн хариуцуулсан этгээдэд тамга, тэмдгийг хадгалуулна.
- 1.7 Энэхүү дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар болбол тухайн асуудлыг Захиргаа удирдлагын баг хэлэлцэж, эцсийн шийдвэрийг Төвийн Захирал гаргана.
- 1.8 Төвийг Захирал, түүнээс эрх олгосноор Төвийн бусад албан тушаалтан удирдана.
- 1.9 Ажилтан нь Ажил олгогчид хандсан санал хүсэлтээ өөрийн шууд удирдлагаар дамжуулж тодорхой санал хүсэлтийг Захиралд уламжилна. Үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүднээс шууд удирдлагаар эсхүл Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнаар дамжуулан ирүүлээгүй саналыг Захирал хүлээн авахгүй.

- 1.10 Төв нь Захирал, захиргаа удирдлагын хэлтэс, Төсөл хөтөлбөр зохицуулалтын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хэлтэс, Судалгаа шинжилгээний хэлтэс гэсэн бүтэцтэй байна. Хэлтэс нь Захирлын өмнө, Төвийн ажилтнууд нь хэлтсийн дарга болон шууд удирдлагын өмнө ажлаа тус тус хариуцна.
- 1.11 Захирал нь Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль, тогтоомжид нийцүүлэн Төвийн дотоод үйл ажиллагаа, хөдөлмөрийн болон бусад асуудлаар тушаал гаргана.
- 1.12 Тухайн асуудлыг шийдвэрлэхээр тушаалыг гаргахдаа төсөл боловсруулсан ажилтан нь өөрийн шууд удирдлагад танилцуулсны дараа саналыг авч, тушаалын төсөлд тусгана. Тушаалын төсөлтэй танилцах хуудсанд шууд удирдлага нь тушаалыг зөвшөөрч гарын үсэг зурсны эцэст Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад танилцуулна. Тушаалын хэрэгжилтэд нэгдсэн бүртгэлээр хяналт тавьж, шаардлагатай тушаалуудын хэрэгжилтийг хэлтсийн дарга нар хариуцаж, Захиралд танилцуулж байна.
- 1.13 Төв нь үйл ажиллагаагаа жилээр төлөвлөж явуулна. Төлөвлөгөөнд байгууллагын эрхэм зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээнүүдийг хэлтэс бүрээр, ажилтан бүрээр тусгаж, нийт ажилтны саналыг тусган Удирдлагын баг хянаж, Захирал батална. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр хэлтэс бүрээр, ажилтан бүрээр тайлан гаргах ба Удирдлагын баг дүгнэнэ.
- 1.14 Ажилтан дараагийн сард гүйцэтгэх ажлыг өмнөх сар дуусахаас өмнө нь шууд удирдлагатайгаа хэлэлцэж төлөвлөгөө гаргасан байна. Ажилтны болон шууд удирдлагын ажлын төлөвлөгөөг холбогдох хэлтсийн даргад танилцуулна. Ажилтны гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнг Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан болон хэлтсийн дарга дүгнэнэ.
- 1.15 Төвийн ажилтан Төв болон бусад Төвтэй шууд буюу шууд бусаар өрсөлдөхүйц ажил, үйлчилгээг гүйцэтгэхийг хориглох бөгөөд Төв болон Төвийн бусад байгууллагатай шууд буюу шууд бусаар өрсөлдөж буй Төв, байгууллага буюу хувь хүний зөвлөх, ажилтан, эрх бүхий албан тушаалтан, хамтрагч/гишүүн буюу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллахыг хориглоно. Түүнчлэн, Төвд ажиллаж байх хугацаанд Төвийн үйлчлүүлэгч буюу ханган нийлүүлэгч байх, эсхүл Төвийн одоогийн болон боломжит үйлчлүүлэгч буюу ханган нийлүүлэгчийн төлөө ажиллах, одоогийн буюу боломжит үйлчлүүлэгч буюу ханган нийлүүлэгчийн хийж буй бизнестэй холбоотой зөвлөгөө өгсний хариуд тухайн үйлчлүүлэгч буюу ханган нийлүүлэгчээс мөнгө, аливаа бусад давуу талыг хүлээн авах зэргийг хориглоно. Сонирхлын зөрчлийн заалтыг зөрчсөн аливаа тохиолдол нь Төвийн дотоод дүрэм, журмыг ноцтой зөрчсөн зөрчилд тооцогдох бөгөөд хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох үндэслэл болно.
- 1.16 Төвд гүйцэтгэж буй ажил, үүрэгтэй холбоотойгоор ажилтан нь Төвийн нууц мэдээлэлтэй танилцах боломжоор хангагдана. Ажилтан нь нууц мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй. Нууц мэдээлэл гэдэг нь ажилтан олж мэдсэн, Төвтэй холбогдох аливаа мэдээлэл, тухайлбал, бизнесийн нууц болгон хамгаалсан мэдээлэл, оюуны өмчийн эрхийн зохицуулалтын дагуу хамгаалагдсан мэдээлэл, хууль тогтоомжийн дагуу эрх олгогдоогүй этгээдэд задруулахыг хориглосон мэдээлэл зэргийг хэлнэ. Мэдээллийн нууцлалыг хадгалах үүргээ зөрчсөн аливаа тохиолдол нь Төвийн дотоод дүрэм, журмыг ноцтой зөрчсөн зөрчилд тооцогдох бөгөөд хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох үндэслэл болно. Баримт бичгийн хяналт шалгалтыг Удирдлагын баг болон шууд удирдлага нар хэрэгжүүлнэ.

2. Ажилд авах, ажлаас халах, ажил хүлээлцэх

- 2.1 Төв ажилд орохыг хүссэн иргэнийг судалсны үндсэн дээр дараах баримт бичгийг бүрдүүлэн авч, зохих үнэлгээг хийж, ажилтны хувийн хэрэг үүсгэн, ажилд авах эсэхийг

тухайн шууд удирдлага, Удирдлагын багийн гишүүд нь ажлын хэсгийн журмаар шийдвэрлэж, зохих саналыг Захиралд танилцуулна:

- (a) ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет, намтар, ажил байдлын тодорхойлолт;
 - (b) иргэний үнэмлэх, боловсролын гэрчилгээ, диплом, мэргэжлийн үнэмлэхийн эх хувь, хуулбарын хамт;
 - (c) Урьд өмнөх ажил олгогчийн тодорхойлолт, тухайн ажилд горилогчийг сайн мэдэх хүний нэр, албан тушаал, утас, цахим хаяг;
 - (d) Шаардлагатай бол жолооны үнэмлэх, эмнэлгийн үзлэгийн, сонгон шалгаруулалтын дүн, оршин суугаа газар буюу иргэний бүртгэлтэй хорооны тодорхойлолт;
 - (e) Шаардлагатай гэж Ажил олгогчоос үзвэл эрүүл мэндийн бүрдмэл үзлэгийн тухай магадалгаа;
 - (f) Шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.
- 2.2 Ажилд авах эсэх судалгааг тодорхой маягт бөглүүлэх, тухайн иргэнээс өөрөөс болон гэр бүлийн гишүүдээс нь тодруулах, холбогдох баримттай нягтлан танилцах, хуулбарыг нь авах, аль нэг байгууллага, албан тушаалтнаас лавлагаа мэдээлэл авах, уулзах, утсаар болон мэйлээр (цахим шуудангаар) холбогдох, харьцуулан шалгах гэх зэрэг болон бусад зохих аргаар гүйцэтгэнэ. Ажилд авах нөхцөлийг хангаагүй байдал нь тухайн ажил, албан тушаалд авч ажиллуулахгүй байх, ажилд авснаас хойш илэрсэн нөхцөл нь ажил, албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно.
- 2.3 Тухайн иргэн ажлын байрны нөхцөлийг хангаж байвал Ажил олгогч энэ тухай тухайн иргэнд мэдэгдэж, Хөдөлмөрийн тухай хуульд заасан гол нөхцөлөөр Ажил олгогч тухайн иргэнтэй гэрээгээр харилцан тохирно.
- 2.4 Хөдөлмөрийн гэрээний гол нөхцөл болон гэрээний бусад нөхцөлийг тохирсон бол ажилтан ажиллуулах, хөдөлмөрийн гэрээ бичгээр байгуулах тухай буюу ажил, албан тушаалын нэр, ажиллаж эхлэх хугацаа, хөдөлмөрийн гэрээний үндэслэл, шаардлага, зохих бусад нөхцөлийг тусгасан тушаалыг Захирал, түүний боломжгүйд орлож буй албан тушаалтан батлах ба тушаалд үндэслэн ажилтан, ажил олгогч нар хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, ажилтанд ажилтны үнэмлэх олгоно.
- 2.5 Хөдөлмөрийн гэрээнд ажлын байрны буюу албан тушаалын нэр, ажилтны гүйцэтгэх ажил, үүрэг, үндсэн цалингийн хэмжээ, хөдөлмөрийн нөхцөл, ажилтан, ажил олгогчийн эрх, үүрэг, хариуцлага, хөдөлмөрийн гэрээний гол болон бусад нэмэлт нөхцөлийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу тусгана.
- 2.6 Төвд ажилд шинээр орох ажилтан нь дараах зүйлтэй танилцана:
- (a) Хөдөлмөрийн дотоод журам, Төвд мөрдөгдөж байгаа бусад дүрэм журам, заавар, Төвийн тухай товч танилцуулга, үйл ажиллагааны үндсэн чиглэл;
 - (b) Ажилтны эрхлэн гүйцэтгэх ажил үүргийн хуваарь, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн нөхцөл;
 - (c) Ажиллах дэг журам, Төвийн нууцын горим, ажилтны ёс зүй, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа болон бусад асуудлаарх холбогдох мэдээлэл.
- 2.7 Хөдөлмөрийн гэрээг тухайн ажилтантай харилцан тохиролцсоноор тодорхой хугацаагаар болон хугацаагүйгээр байгуулна.

- 2.8 Туршилтын болон сургалтын хугацаа дуусгавар болох үед тухайн ажилтан ажлын байранд дахь шаардлагыг бүрэн хангаж байгаа эсэхээс хамааран, хөдөлмөрийн гэрээгээр үргэлжлүүлэн ажиллуулах эсэхийг Захирал, түүний боломжгүйд орлож буй албан тушаалтан шийдвэрлэнэ. Ажилтан ажлын байрны нөхцөл, шаардлагыг хангаж байна гэж Ажил олгогч үзвэл тухайн ажилтны хувьд Хөдөлмөрийн гэрээний хугацааг уг гэрээнд зааснаар хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 2.9 Тухайн ажилтны ажлын үр дүнг Удирдлагын баг хангалтгүйд тооцвол хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болсноор хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох бөгөөд цаашид сунгагдахгүй.
- 2.10 Хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцлахаар бол ажил хүлээлцэх хугацааг Ажил олгогч Ажилтанд мэдэгдэнэ. Ажил хүлээлцэх үеийн цалин хөлсийг ажилтанд Хөдөлмөрийн тухай хууль болон Захирлын тушаалд зааснаар тооцож олгоно.
- 2.11 Ажилтан нь ажлаа өөрчлөх, өөр газар шилжих, хөдөлмөрийн гэрээгээ өөрөө цуцлахыг хүсвэл цуцлах өргөдлөө Төвийн удирдлагад бичгээр гаргана. Ажилтны өөрийн сайн дураар гаргасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор ажил хүлээлцэнэ.
- 2.12 Хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлийн дагуу цуцална.
- 2.13 Дараах зөрчлийг хөдөлмөрийн сахилгын ноцтой зөрчилд тооцож, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар шууд цуцална:
- (a) Шууд удирдах албан тушаалтны гаргасан зөвлөмж, удирдамж, зааварчилгаа, эсвэл ажил олгогчийн дүрэм, бодлого зааварчилгаа, ёс зүйн дүрмийг зөрчиж, тодорхой үндэслэлгүйгээр эсэргүүцэн маргасан, үл ойшоосон, эсхүл биелүүлээгүй;
 - (b) Ажилд орохдоо хууран мэхэлсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, нуун дарагдуулсан, Төвөөс шийдвэр гарахад нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсгэсэн, хувийн бусад мэдээллийг нуун дарагдуулсан, хууран мэхэлсэн, хуурамчаар бүрдүүлсэн, тухайлбал хувийн анкет, ажлын үнэлгээ, бусад баримтыг, тодорхой хугацааны шаардлагыг хангаагүй нь тодорхой болсон, эсхүл тодорхой хугацааг хуурамчаар мэдүүлсэн;
 - (c) Хууран мэхлэх замаар, эсхүл Төвд мэдэгдэхгүйгээр Төвийн нэрийг ашиглаж банкнаас болон бусад байгууллагаас зээл авсан, хөрөнгө худалдаж авсан;
 - (d) Ажлын цагаар гүйцэтгэх ёстой ажлаа хэрэгжүүлээгүй, эсхүл өөрийн шууд удирдагчийн зөвшөөрөлгүйгээр ажлын байраа орхиж явсан, эсхүл зөвшөөрөгдөөгүй ажил гүйцэтгэсэн, бусдын ажлыг дур мэдэн гүйцэтгэсэн, эсхүл гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ бичгээр өгөх зөвшөөрөлгүйгээр бусдад дур мэдэн шилжүүлсэн, эсхүл Ажлын цагаар Ажилтан хувийнхаа ажлыг хийсэн;
 - (e) Хууль, хуулиас бусад тогтоомж, аюулгүй ажиллагааны дүрэм, журам зөрчсөн, зохих үүргээ биелүүлээгүй, үүний улмаас бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд эрсдэл учруулсан, эсхүл бодит хохирол учруулсан;
 - (f) Ялгаварлан гадуурхах, хүчирхийллийн зан араншин гаргасан, тэр дундаа бэлгийн болон жендерийн эсрэг зөрчил гаргасан;
 - (g) Ажлын цагаар буюу ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн, мансууруулах зүйл хэрэглэсэн, ажлын байранд согтууруулах ундаа авчирсан, согтуурсан үедээ ажилдаа ирсэн;

- (h) Захиргаанд урьдчилан мэдэгдэлгүйгээр ажлын цагаас 2 цаг буюу түүнээс дээш хугацаагаар 3 буюу түүнээс дээш удаа ажлын байрандаа хожимдсон, дараалсан 3 хоногийн хугацаагаар урьдчилан авсан зөвшөөрөлгүйгээр ажилдаа ирээгүй, эсхүл ажлын цагаас эрт тарж явсан, цалинтай болон цалингүй чөлөөний хугацааг хэтрүүлэн ажил тасалсан, хүндэтгэх шалтгаантайгаа мэдэгдсэн боловч ирэхдээ нотлох баримтгүй буюу хуурамч баримт бүрдүүлсэн, цагийн бүртгэлээ хууран мэхэлж бөглөсөн;
 - (i) Ажил олгогч, агент эсвэл гэрээт байгууллага, харилцагч болон зочид, хамт ажиллагсдын өмч хөрөнгийг хулгайлсан, эсхүл Ажил олгогчийн өмч хөрөнгийг зөвшөөрөлгүй хэрэглэж, авч гарсан буюу авч гарахыг завдсан, худалдсан, хувьдаа ашигласан, завшсан, залилсан, эсхүл мөнгө буюу эд хөрөнгө хариуцсан ажилтан Төвийн удирдлагын итгэлийг алдсан, эсхүл бичиг баримт хуурамчаар үйлдсэн, засварласан болон ашигласан;
 - (j) Ажил олгогч эсвэл харилцагчдын нууц мэдээллийг гуравдагч этгээдэд задруулсан, Төвийн нууц мэдээллийг өөрт ашигтайгаар ашигласан;
 - (k) Төвийн нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх аливаа үйлдэл, эс үйлдэл гаргасан, эсхүл Төвийн үйл ажиллагаа болон бизнесийн нэр хүндийг нь гутаах зэргээр түүний эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөхүйц сөрөг үр дагавар бий болгосон, эсхүл ажил үүргээ гүйцэтгэсний төлөө бусдаас шан харамж авсан, бусдыг ямар нэг үүрэг хүлээх байдалд оруулсан, бусад Төв болон байгууллагад ажил, үйлчилгээ үзүүлсэн, давхар ажил хийсэн;
 - (l) Монгол Улсын хуульд заасны дагуу Ажилтан гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдон ял оногдуулсан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;
 - (m) Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрмийг 2 буюу түүнээс удаа дагаж мөрдөөгүй, ослыг мэдээлээгүй, Ажилтан нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны болон технологийн ашиглалтын дүрэм, горимыг ноцтой зөрчсөн гэж холбогдох хэлтэс, удирдлагаас нь үзсэн;
 - (n) Сахилгын шийтгэлтэйд тооцох хугацаа өнгөрөөгүй байхад сахилгын ноцтой биш зөрчлийг 2 буюу түүнээс дээш удаа гаргасан;
 - (o) Ажил олгогчийн оффис болон ажлын байранд, мөн Ажил олгогчоос зохион байгуулж буй Төвийн арга хэмжээний үеэр Төвийн албан тушаалтан, ажилтан, гэр бүлийн гишүүдийн эсрэг танхайрсан, зодсон, эрүүл мэндэд нь санаатайгаар гэмтэл учруулсан, гүтгэсэн, доромжилсон, эд хөрөнгө эвдэж сүйтгэсэн, зэвсэг хэрэгсэл хэрэглэсэн.
- 2.14 Ажил олгогчийн Хөдөлмөрийн дотоод журам буюу сахилгын журам, хөдөлмөрийн гэрээнд заасан ноцтой бусад зөрчлийг гаргасан зэрэг байна.
- 2.15 Аливаа ажилтан нь дээд удирдлагын шийдвэр гараагүй байхад аль нэг ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлах талаар тухайн ажилтан болон бусад ажилтанд урьдчилан мэдэгдэхийг хориглоно. Ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлах талаар шууд удирдлага нь хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд санал болгож болно. Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нь шууд удирдлагаас нэмэлт мэдээлэл, баримтыг шаардаж болох бөгөөд шууд удирдлага нь шаардсан мэдээлэл, материалыг зохих ёсоор гаргаж өгнө. Саналыг судлан үзсэний дараа Захиралд тушаалын төслийг танилцуулна. Захирал тушаалын дагуу эцэслэн шийдвэрлэнэ.
- 2.16 Сахилгын зөрчлийг шууд удирдлага болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан судлан тогтооно. Сахилгын шийтгэлийг ногдуулах үндэслэлтэй бол хүний нөөцийн

асуудал хариуцсан ажилтан болон ажилтны шууд удирдлага нь сахилгын шийтгэлийн арга хэмжээг сонгож төлөвлөнө. Сахилгын арга хэмжээг Захирлын тушаалаар ногдуулна. Сахилгын шийтгэлийн зохих тэмдэглэл болон тушаалыг ажилтанд танилцуулна.

- 2.17 Ажилтан сахилгын ноцтой зөрчлийг гаргасны улмаас тухайн ажилтны хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлээр Ажил олгогчийн санаачилгаар шууд цуцалж байгаа тохиолдолд ажлаас халагдсан тухай мэдэгдлийг нэг сарын өмнө өгөхгүйгээр Хөдөлмөрийн гэрээг ажил олгогч цуцлах бөгөөд ажлаас халагдсаны тэтгэмж ажилтанд төлөгдөхгүй.
- 2.18 Хөдөлмөрийн гэрээг цуцлах буюу ажилтныг ажлаас халах асуудлыг Захирал, түүний боломжгүйд орлож буй албан тушаалтны тушаалаар шийдвэрлэнэ. Хөдөлмөрийн гэрээг цуцалсан буюу ажлаас халсан үндэслэлийг уг тушаалд тусгана.
- 2.19 Ажил олгогч өөрийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлахдаа хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, ажил хүлээлцэх хугацаа, тойрох хуудас зуруулах нөхцөл болон Хөдөлмөрийн тухай хуульд заасан бусад нөхцөлийг Ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай тушаалд зааж өгнө.
- 2.20 Төв ажлаас халагдсан ажилтны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт тэмдэглэл хийж, тойрох хуудсаар ажлаа хүлээлцэхийг ажилтан бүрэн хийлгэж дууссаны дараа Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлээр ажлаас халагдсаны тэтгэмжийг нэг удаа олгоно.

3. Ажилтны эрх, үүрэг

3.1 Ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

- (a) Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан дотоод журам, өөрийн ажлын нөхцөл, чиг үүрэгтэй танилцах;
- (b) Хөдөлмөрийн аюулгүй болон эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын нөхцөлөөр хангагдах;
- (c) Цалин хөлсийг тухайн сард 2 хэсэгт хувааж авах;
- (d) Хууль ёсны эрх, ашиг сонирхлоо Хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх эрх бүхий байгууллага, эсхүл шүүхээр хамгаалуулах;
- (e) Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулах, Хөдөлмөрийн гэрээ бичгээр байгуулагдаагүй бол ажлаа эхлүүлэхгүй байх, Хөдөлмөрийн гэрээний нэг хувийг өөртөө авч үлдэх;
- (f) Хөдөлмөрийн гэрээ, түүний гол болон бусад нөхцөлийн талаар санал бодлоо илэрхийлэх, Хөдөлмөрийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар Ажил олгогчид санал, хүсэлтээ дэвшүүлэх;
- (g) Хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу өөрийн санаачилгаар цуцлах;
- (h) Хөдөлмөрийн гэрээг Ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар цуцлахаар болсон бол энэ тухай мэдэгдлийг нэг сарын өмнө бичгээр авах;
- (i) Хөдөлмөрийн гэрээг ажил олгогч өөрийн санаачилгаар цуцалсан бол Захирлын тушаалтай танилцах, тушаалын хувийг халагдсан өдөртөө авах;

- (j) Өөрийн ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэг, Хөдөлмөрийн дотоод журам, Төвийн үйл ажиллагааны талаар санал бодлоо хэлэх, тухайн асуудалд өөрийн байр сууриа илэрхийлэх, тайлбар өгөх, шууд удирдах албан тушаалтны зүй бус үйл ажиллагаа, ёс зүйгүй, зохисгүй, үндэслэлгүй заавар, үүрэг даалгаврын талаар Төвийн удирдлагад гомдол гаргах, гомдлын хариугаа авах;
- (k) Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад хуульд зааснаар бусад эрхтэй.

3.2 Ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

- (a) Ажлаа үнэнч шударгаар, түргэн шуурхай, мэргэжил, мэргэшлийн ур чадвараа дайчилж, ажил олгогчоос тавьсан шаардлагын буюу зохих чанарын түвшинд, холбогдох хуулийн нөхцөл, ажлын байрны онцлогд нийцүүлэн чиг үүргээ гүйцэтгэх;
- (b) Өөрийн байгуулсан Хөдөлмөрийн гэрээний нөхцөл, ажлын явцад өөрийн зөвшөөрсөн бөгөөд харилцан тохирсон зүйлээсээ татгалзахгүй байх, худал амлалт, мэдээлэл өгөхгүй байх, хөдөлмөрийн гэрээний төсөл болон түүний нэмэлт, өөрчлөлтийг ажлын 3 хоногийн дотор хянан танилцаж, гарын үсэг зурах;
- (c) Төвийн Хөдөлмөрийн дотоод журам, шийдвэр, энэхүү Хөдөлмөрийн гэрээ, үйл ажиллагааны заавар, журам, ёс зүйн хэм хэмжээний зарчмууд гэх зэргийг сахин биелүүлэх, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээгээр хориглосон зүйлийг зөрчихгүй байх;
- (d) Төвийн ажилтнууд болон бусад байгууллагын ажиллагсад, иргэдтэй харьцахдаа харилцааны соёлыг эрхэмлэх, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах, эрхэлсэн ажилтай холбоотой санал, шүүмжлэл, эрэлт, хүсэлтэд анхааралтай хандаж санал шүүмжлэлийн дагуу ажилдаа дүгнэлт хийж, ажлаа сайжруулах, үйл ажиллагаагаа тогтмолжуулах, өөрийн үндсэн үүрэгт ажлаа соёлтой шуурхай гүйцэтгэхийн зэрэгцээ бусдын ажилд туслалцаа үзүүлэх, хавсран болон орлон гүйцэтгэх
- (e) Ажил олгогчийн болон шууд удирдах албан тушаалтны заавар зөвлөгөө, үүрэг даалгаврыг эсэргүүцэн маргалдахгүй байх, үл ойшоохгүй байх, хайхрамжгүй хандахгүй байх, буруу биелүүлэхгүй байх, удирдлагын заавар, удирдамж, шийдвэрийг хугацаанд нь, бүрэн гүйцэд сахин биелүүлэх, Ажлын цагаар ажил, гүйцэтгэх ёстой чиг үүргээс өөр зүйл хийхгүй байх, ажлын байраа шууд удирдлагын зөвшөөрөлгүйгээр орхиж явахгүй байх;
- (f) Мэргэжил, эрүүл мэнд, ур чадвар, хувийн байдлын хувьд тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хөдөлмөрийн гэрээ байгуулах болон ажлаа эхлэхээс өмнө тухай бүрд нь хангасан байх, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүрэгт ажлаа мэдлэг боловсрол, авьяас чадвараа дайчлан бүрэн, чанартай гүйцэтгэж, хөдөлмөрийн сахилгыг сахиж, үр бүтээлтэй, идэвх санаачилгатай, үнэнч шударгаар ажиллах, Төвийн шаардлагын дагуу хэлний сургалтад хамрагдаж гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх;
- (g) Хөдөлмөрийн аюулгүйн ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг сахин биелүүлэх, үйлдвэрлэлийн осол, гэмтэл, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүйн ажиллагааны зааврыг чанд сахин мөрдөх, осол зөрчлийг цаг алдалгүй мэдээлэх, осолд өртөгсдөд туслах, эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж байх, мэргэжлийн болон бусад сургалт, арга хэмжээнд биечлэн идэвх, хариуцлагатай оролцох, өөрийн ажил мэргэжлийн мэдлэг чадварыг байнга сайжруулах;

- (h) Төвийн бизнесийн болон технологийн, үйлдвэрлэлийн, санхүүгийн, үйл ажиллагааны болон бусад нууцлалыг хадгалах, бусдад задруулахгүй байх, ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа үйл ажиллагаатай холбоотой аливаа нууц мэдээ, мэдээлэлтэй, үүний дотор Төвийн бизнестэй холбоотой аливаа мэдээлэл, томьёо, тооцоо, зураглал, төлөвлөгөө, санаачилга, эрдсийн сорьц, загвар, арга зүй, технологи, санхүүгийн тайлан, ажилчдын цалин хөлс, түүнтэй холбоотой тоо мэдээ, бизнесийн бусад нууц, санамж бичгүүд, протокол, ноу-хау (цаашид **“Нууц мэдээлэл”** гэх) гэх зэрэг нууц мэдээллийг Төвийн өмч хэмээн хүлээн зөвшөөрч, аливаа этгээдэд задруулахгүй, ямар нэгэн байдлаар ашиглахгүй, хуулбар авч үлдэхгүй, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх;
- (i) Төвийн өмч хөрөнгийг ариглан хамгаалж ажлын байр, хариуцсан эд хөрөнгө, машин техник, тоног төхөөрөмж бусад зүйлийг зориулалтын дагуу, үр ашигтай ашиглах, хувийн болон албан бус зорилго хэрэгцээнд ашиглахгүй, хэрэглэхгүй байх, Төвийн байрнаас гадуур зөвшөөрөлгүйгээр эд хөрөнгө болон мэдээллийг авч гарахгүй байх, албан ажлын бичиг баримтын ноорог, цаашид ашиглагдахгүй гэж үзсэн тоо баримт, мэдээллийн тэмдэглэл, бичлэгийг устгаж байх, ус, гал түймрийн аюул гарахаас тогтмол сэргийлэх, албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин компьютерыг гадагш авч гарахгүй байх, иж бүрдлийг салгахгүй байх, стандартын бус программ, тоглоомын программ суулгахгүй байх;
- (j) Хөдөлмөрийн гэрээ цуцлагдах мэдэгдэл авсны дараа, эсхүл ажил хүлээлцэх хугацаанд Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ чанд сахин биелүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг буруулахгүй байх, Ажил олгогчийн эд хөрөнгө, өдөр тутмын үйл ажиллагаанд хохирол учруулахгүй, элдэв саад хийхгүй, ажилдаа хайнга хандахгүй байх;
- (k) Хөдөлмөрийн гэрээ цуцлагдах/дуусгавар болох үед хариуцсан ажил, эд хөрөнгө, баримт бичиг, цахим болон бусад мэдээллийг шууд удирдлагад Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох Гүйцэтгэх захирлын тушаалд зааснаар хүлээлгэн өгөх, зохих журмын дагуу холбогдох тооцоог хийж дуусгах, тойрох хуудсаа бөглүүлэх;
- (l) Хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачилгаар цуцлахаар бол нэг сарын өмнө бичгээр ажил олгогчид мэдэгдэх, мэдэгдлээ нотариатаар гэрчлүүлэх;
- (m) Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ байгууллагад учруулсан хохирлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт зааснаар нөхөн төлөх;
- (n) Ажил олгогчоос зөвшөөрсөн эсхүл үндсэн ажилд нь саад болохооргүй байгаагаас бусад тохиолдолд өөр ажлын байранд давхар ажил хийхгүй байх, Төвийн бизнесийн үйл ажиллагаатай ижил төстэй, эсвэл түүнтэй өрсөлдөхүйц ажил эрхэлдэг байгууллагын үйл ажиллагаанд Захирлын зөвшөөрөлгүйгээр ямар нэгэн хэлбэрээр оролцох, өөрийн ажил үүргийн хуваарьт заасан үүргийг өөр аж ахуйн нэгжид давхардуулан гүйцэтгэх, түүнчлэн энэ талаар бусадтай ямар нэгэн гэрээ, хэлцэл байгуулах зэрэг үйлдэл хийхгүй байх;
- (o) Албан томилолт, амралт өвчтэй буюу чөлөө авсан ажилтан энэ хугацаанд өөрийн гүйцэтгэх ажил, үүргийг орлох ажилтандаа хүлээлгэн өгч, дээрх хугацаанд хийж гүйцэтгэх ажил, тооцоо судалгаа, шаардлагатай материалын талаар бүрэн ойлголттой болгохын хамт гүйцэтгэлийг тооцон хүлээлцдэг журмыг баримтлах;
- (p) Ажилтан Төвийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа эрхлэн явуулж байх үедээ бусад этгээдийн нөлөөнд автан авлига, шан харамж, хээл хахууль авсан нь нотлогдож Төвийн нэр өр, эд хөрөнгөд хохирол учруулбал хохирлыг бүрэн хариуцах;

- (q) Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль, хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан бусад үүргээ биелүүлнэ.

4. Ажил, амралтын цаг

- 4.1 Төв ажлын цагийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасныг үндэслэн тогтоож мөрдөнө.
- 4.2 Улаанбаатар дахь оффист долоо хоногийн ердийн ажлын өдрүүд буюу Даваа, Мягмар, Лхагва, Пүрэв, Баасан гарагийн ажлын цагийн үргэлжлэх хугацаа 8 цаг байх бөгөөд ажил өглөөний 8:00 цагт эхэлж, оройны 17:00 цагт дуусна. Тухайн ажилтны ажлын онцлогоос хамааран ажлын өөр хуваарьтай байж болно. Ердийн ажлын өдрийн дундах ажилтны амарч, хооллох завсарлагын үргэлжлэх цалингүй хугацаа 12:00-13:00 цагийн хооронд байна. Төвийн удирдлага үйл ажиллагаанаас хамааран үдийн цайны завсарлагын хугацааг өөрчилж болно.
- 4.3 Төвийн үйл ажиллагааны хэрэгцээ, шаардлага, тухай ажлын байрны онцлог зэргийг харгалзан ажлын цаг, түүний хуваарийг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу ажил олгогч өөрчилж болно.
- 4.4 Амрах, хооллох, нийтийн завсарлагаанаас гадна хүүхдээ хөхүүлэх, асрахад зориулан зургаан сар хүртэлх насны хүүхэдтэй буюу нэг хүртэлх насны ихэр хүүхэдтэй эхэд хоёр цагийн, зургаан сараас нэг хүртэлх насны, түүнчлэн нэг нас хүрсэн боловч эмнэлгийн дүгнэлтээр зайлшгүй асаргаа шаардагдах хүүхэдтэй эхэд нэг цагийн завсарлага нэмж олгоно. Энэ нь ганц бие эцэгт нэгэн адил хамаарна.
- 4.5 Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагыг ажилласан цагт оруулан тооцно.
- 4.6 Илүү цагаар ажилтан ажилласан бол нөхөж амрах зарчмыг баримтална. Төв ажлын шаардлагын дагуу, шууд удирдлагаас даалгаснаар өдрийн ажлын цагийг хэтрүүлэн илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол ажилласан цагийг бүртгэлийг үндэслэн түүнд 1.5 дахин нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно. Илүү цаг ажиллахын өмнө ийм шаардлагыг дэлгэрэнгүй тайлбарласан хуудас бөглөж шууд удирдлага, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнаар батлуулах бөгөөд нөхөн амруулах буюу нэмэгдэл цалин олгох эсэхийг энэ хуудаст тэмдэглэсэн байна.
- 4.7 Ажилтан нь ажилдаа өглөө ирсэн, завсарласан, ажлаас тарсан цагаа бүртгэнэ. Ажлын цагийн бүртгэл, ажилтны ажлын цагийн ашиглалтын байдалд шууд удирдлага хяналт тавина. Ажлын цагийн ашиглалтын тайланг сар бүр гаргаж Ажилтан нэгтгэн мэдээлж байна.
- 4.8 Ажлын цаг ашиглалтад шууд удирдлага болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хяналт тавьж бүртгэл хөтлөх бөгөөд ажилтан ажил эхлэх, завсарлах болон тарах цагийг баримтлан ажлын цагийн үргэлжлэх хугацаанд ажил дээрээ тогтвортой ажиллах үүрэгтэй.

5. Чөлөө олгох

- 5.1 Ажилтан нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирэх боломжгүй болсон тохиолдолд удирдлагад заавал мэдэгдэж зохих журмын дагуу чөлөө зөвшөөрөл шууд удирдлага болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнаас авна.
- 5.2 Ажилтанд нэг удаагийн чөлөө олгохдоо түүний ажлын гүйцэтгэл, зайлшгүй шаардлага, хугацаа зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхой хугацаагаар чөлөө олгож болно.

Чөлөөг цалинтай олгох эсэхийг шууд удирдлага болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нар шийдвэрлэнэ.

- 5.3 Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр захиргааны чөлөөг хэтрүүлсэн, удаа дараа хүндэтгэх шалтгаангүйгээр ажлаас хожимдсон, ажил тарах цагаас өмнө ажлаас явсан хугацааг ажил тасалсанд тооцож энэ журам болон хөдөлмөрийн гэрээнд заасан нөхцөлөөр сахилгын шийтгэл ноогдуулна.
- 5.4 Ажилтан өөрөө болон гэр бүлийн хүмүүсээ эмнэлэгт үзүүлсэн, эмчилгээ хийлгэсэн, байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон зэрэг хүндэтгэх шалтгаанаар ажилдаа байгаагүй хугацааг зохих баримтыг үндэслэн ажлаас хожимдсон буюу ажил тасалсан гэж үзэхгүй. Харин энэ тухайгаа ажилтан шууд удирдлагад болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд урьдчилан заавал мэдэгдсэн байх үүрэгтэй бөгөөд зохих нотлох баримтыг Ажилтан Ажил олгогчид гаргаж өгөх үүрэгтэй.
- 5.5 Чөлөөний хугацааг дахин нэг удаа сунгаж болно. Чөлөө авах нийт хугацаа нэг жилд 10 хоногоос дээш хэтрэхгүй байна.
- 5.6 Чөлөөтэй байх хугацаанд нь тухайн ажилтанд Төвөөс тэтгэмж, тусламж олгох асуудлыг тухай бүрд нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэл, нөхцөлөөр Төвийн дотоод журмын дагуу Ажил олгогч шийдвэрлэж байна.

6. Ээлжийн амралт

- 6.1 Төв нь Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтнуудад жил бүр нийтээр амрах баярын өдөр, үүнээс гадна жилд ажлын 15 болон түүнээс дээш хоногоор ээлжийн амралтыг эдлүүлэх ба амралтын хуваарь нь Төвийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр зохицуулагдана. Нийтээр амрах баярын өдөр гэдэгт Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ойлгоно.
- 6.2 Ажилтан нь ээлжийн амралт эдлэх саналаа жил бүрийн эхэнд өөрийн шууд удирдлага болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд мэдэгдэх ба шууд удирдлага болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан нь амралтын хүсэлтүүдийг хянаж үзээд хуваарь гарган, баталсан хуваарийн дагуу амралт эдлэх хүсэлтийг шийдвэрлэнэ.

7. Төвийн эрх, үүрэг

- 7.1 Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, бусад хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу Ажил олгогч буюу Төв дор дурдсан эрх эдэлнэ:
- (a) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, журам, шийдвэр, үйл ажиллагааны болон технологийн заавар, журам, ёс зүйн хэм хэмжээг батлан мөрдүүлэх, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан бүхий л дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, Ёс зүйн хэм хэмжээ, Хүний нөөцийн бодлого, журам гэх зэрэг баримт бичгүүд, мөн Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг ажилтнаас биечлэн, утсаар, цахим сүлжээгээр, бичгээр болон бусад хэлбэрээр шаардах;
 - (b) Ажилтан өөрийн буруугаас холбогдох сургалтад хамрагдаагүй, Ажил олгогчоос даалгасны дагуу Хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолттой танилцаагүй, хүлээн зөвшөөрсөн тухай гарын үсэг зураагүй байвал Ажилтнаар Ажил гүйцэтгүүлэхээс татгалзах;
 - (c) Хөдөлмөр, үйлдвэрлэлийн аюулгүйн ажиллагаа, эрүүл ахуйн журам, хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн зарчим, Ажил олгогчийн бусад шийдвэрийг даган мөрдөж

буй байдалд хяналт тавих, бүртгэл хөтлөх, эдгээр журмыг Ажилтан зөрчсөн бол сахилгын болон бусад арга хэмжээ авах, эд хөрөнгийн хариуцлага, энэ журамд заасан бусад хариуцлагыг зохих үндэслэл, журмын дагуу ногдуулах;

- (d) Хөдөлмөрийн үйл ажиллагаа, Ажлын байр, чиг үүрэг, Хөдөлмөрийн бусад асуудлаар холбоотойгоор Ажилтанд заавар, удирдамж өгөх, ажлын байрны тодорхойлолт батлах, эдгээрийг хугацаанд нь, зохих ёсоор биелүүлэхийг Ажилтнаас шаардах, гүйцэтгэлд нь хяналт тавих, мөрдүүлэх, ажилтныг хуулийн дагуу өөр ажлын байранд түр болон бүр мөсөн томилох;
- (e) Ажилтан тухай ажлын байранд эрүүл мэндийн шаардлагыг хангаж буй эсэхийг шалгуулах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд Ажилтныг хамруулах, шинжилгээний хариуг авч хадгалах, ажилтан эрүүл мэндийн хувьд тухайн ажлын байрны шаардлагыг хангаж чадахгүй бол ажилд авахаас татгалзах, энэхүү Хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу цуцлах;
- (f) Төвийн техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хэрэгслийг хэрэглэх зааврыг батлан мөрдүүлэх, ашиглалтад нь хяналт тавих, зориулалтын дагуу ашиглаагүй, мөн зааврыг зөрчсөн, санаатайгаар буюу зориудаар гэмтээсэн ажилтанд арга хэмжээ авах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, үүний тулд цалингаас зохих суутгал хийх;
- (g) Хөдөлмөрийн хөлс, үндсэн цалин, бусад төлбөр урамшууллыг тухайн ажлын байрны онцлог, чиг үүрэг, зэрэг дэв, бусад нөхцөл байдлыг харгалзан тогтоох;
- (h) Ажилтны ажил, амралтын цагийг Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу тогтоох, өөрчлөх, ажлын шаардлагын дагуу хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр ажилтныг илүү цагаар ажиллуулах;
- (i) Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусгавар болж, цаашид сунгагдахгүй болсноос гэрээ дуусгавар болсон, хөдөлмөрийн гэрээ цуцлагдсан бол ажилтанд халагдах үед нь Хөдөлмөрийн тухай хуульд заагаагүй элдэв тэтгэмж, тусламж, эд хөрөнгийн туслалцааг төлөх, үзүүлэхээс татгалзах;
- (j) Ажилтан өөрийн хариуцсан ажил, эд хөрөнгө, баримт бичиг, цахим болон бусад мэдээллийг шууд удирдлагадаа хүлээлгэн өгөх, Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх хүртэлх хугацаанд Ажилтны цалин болон бусад тооцоог хийхгүй байх, Нийгмийн даатгалын дэвтэр, бусад баримт бичгийг Ажилтанд олгохгүй байх;
- (k) Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд заасан үндэслэл журмын дагуу өөрийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах
- (l) Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль, Төвийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд заасан бусад эрхтэй.

7.2 Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу Ажил олгогч дараах үүргээ биелүүлнэ:

- (a) Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан Төвийн дотоод журам, Ажлын байрны нөхцөл, чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг Ажилтанд танилцуулах, холбогдох сургалтад хамруулах, холбогдох баримт бичгүүдтэй танилцах боломжийг Ажилтанд олгох, Хөдөлмөрийн аюулгүй болон эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын нөхцөлөөр хангах;

- (b) Хөдөлмөрийн гэрээ, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр байгуулж байхад анхаарах, Хөдөлмөрийн гэрээ бичгээр байгуулагдаагүй байгаа үед Ажилтнаас ажлаа хийх, эхлүүлэхийг шаардан тулгахгүй байх;
- (c) Ажилтны цалин тооцоог Хөдөлмөрийн гэрээ, Хөдөлмөрийн харилцааг зохицуулсан дотоод дүрэм, журмын дагуу төлөх;
- (d) Ажилтныг хуульд заасан үндэслэлээр өөр ажилд шилжүүлэх, Ажилтанд урьдчилан мэдэгдэж тохиролцсоноор түүний амралтын цагийг өөрчлөх;
- (e) Ажилтанд харилцагчийн байранд ирж очих, байрлахад шаардагдах зардлаар хангах;
- (f) Ажилтан ажил хийсний дараа амрах эрхийг эдлүүлэх;
- (g) Ажилтанд сахилгын шийтгэл ногдуулахаас өмнө тухайн зөрчлийг шинжтэй үйлдэл, эс үйлдлийг судлан тогтоох, зөрчлийн талаарх холбогдох маягтыг бөглөх, бөглүүлэх, сахилгын шийтгэл оногдуулах болсон үндэслэлийг Ажилтанд танилцуулах;
- (h) Ажилтны нэр төр, нэр хүндийг хүндэтгэх, түүнтэй соёлтой зохих түвшинд харьцах, ажилтны хувь хүний нууцыг хадгалах, ажилтны ажиллах аятай нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, ажлын байр, багаж, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон бусад шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр хангах, ажилтны мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, сургууль дамжаанд суралцуулах зэрэг ажлыг зохион байгуулахын хамт ажилтнуудын дунд ажил хэрэгч, хамтач, бүтээлч уур амьсгалыг бий болгох, идэвх санаачилгыг дэмжих, ажилтнаас тавьсан санал, эрэлт хүсэлтийг авч хэлэлцэн шийдвэрлэж, авсан арга хэмжээний талаар мэдээлж байх, хөдөлмөрийн хууль, тогтоомж, хөдөлмөр хамгааллын дүрэм, зааврыг чанд мөрдөж, ус, галын аюул, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- (i) Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу зохих татвар, суутгалыг төлж байх, холбогдох бичилтийг хийж баталгаажуулж байх;
- (j) Ажилтан өөрийн ажил үүргээ зохих түвшинд гүйцэтгэхэд нь зориулж шаардлагатай мэдээлэл, удирдамж, заавар, зөвлөгөө гэх зэргээр хангах, ажилтны ажиллах нөхцөл болон нийгмийн асуудлын талаар хөдөлмөрийн гэрээнд тодорхой тусгах. Түүнчлэн ажилтны хүсэлтээр ажил, мэргэжил, мэргэшил, ажлын ур чадвар, албан тушаал, хөдөлмөрийн хөлсний тухай тодорхойлолт гаргаж өгөх;
- (k) Ажилтанд заавар, зөвлөмж, удирдамж өгөхдөө тухайн ажилтны саналыг харгалздаг байх, ажилтанд хууль бус бөгөөд зүй бус шаардлага тавихгүй байх, өөрийн заавар зөвлөгөөг ойлгомжтой, тодорхой байдлаар илэрхийлдэг байх, хууль бус бөгөөд зүй бус заавар, үүрэг даалгавар өгсөн бол тэр даруйд нь өөрөө хүчингүй болгодог байх, ажлын зохион байгуулалт, материаллаг нөхцөл, сахилга, хариуцлага, дэг журам, ажлын цагийн ашиглалт, үр дүнг сайжруулахтай холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- (l) Ажилтныг жилд нэг удаа эрүүл мэндийн шинжилгээнд хамруулж зардлыг нь хариуцах;
- (m) Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль, Төвийн дүрэм, хөдөлмөрийн дотоод журамд заасан бусад үүргээ биелүүлнэ.

8. Цалин хөлс, хангамж

- 8.1 Ажилтнуудын үндсэн цалин дээр нэмж олгох нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг энэ талаарх хүчин төгөлдөр мөрдөж байгаа холбогдох заавар, журамд заасны дагуу олгоно.
- 8.2 Ажилтны цалинг ажлын цагийн бүртгэлийг үндэслэн ажилласан цаг, хоног, хөдөлмөрийн бүтээмжийг харгалзан олгоно.
- 8.3 Ажилтны сарын үндсэн цалинг сард хоёр удаа, сар бүрийн 05 болон 20-ний өдөр олгох бөгөөд ингэхдээ зохих суутгал хийсний дараа ажилтны дансанд шилжүүлнэ. Хэрэв цалин олгох өдөр нь баярын болон амралтын өдөр таарвал түүний өмнөх өдөр олгоно.
- 8.4 Илүү цаг ажилласныг биеэр эдлүүлж амрахгүй бол хөлсийг сар бүрийн сүүлийн цалин дээр бодож олгоно.
- 8.5 Ажилтанд өвчтэй байх хугацаанд тэтгэмж олгох эсэхийг Ажил олгогчийн шийдвэрээр шийдвэрлэнэ.
- 8.6 Төв нь тухайн нөхцөлд өрсөлдөхүйц бөгөөд шударга цалин хөлс, хангамжийг олгоно. Ажилтан нь гүйцэтгэж буй ажлын нарийн төвөгтэй байдал, хариуцлагын хэмжээ, ажлын туршлага, мэргэжил, мэргэшлийн түвшин болон ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай боловсролын түвшин зэрэгт тохирсон цалин хөлс авна. Хөдөлмөрийн гэрээнд цалин хөлстэй холбогдох заалтыг тусгасан байна.
- 8.7 Ажил үүрэгтэй холбоотой гар утасны хэрэглээний төлбөрийг албан ёсны баримтаар нөхөн олгоно.
- 8.8 Төв нь ажилтнуудыг өөрийн ажлын болон хувийн ур чадварыг сайжруулан өөрийгөө хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, шаардлагатай сургалтаар хангана. Төв нь өөрийн зохион байгуулсан сургалтын зардлыг хариуцах бөгөөд үүнд сургалтын төлбөр, онгоцны тийз, зочид буудлын үнэ, хоол болон бусад холбогдох зардал орно. Ажилтан нь хичээлд бүрэн суух бөгөөд шалгалт авах тохиолдолд шаардлагатай бүхий л шалгалтыг амжилттай өгсөн байна.

9. Хөдөлмөрийн сахилга зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- 9.1 Хөдөлмөрийн хууль тогтоомж болон Төвийн журам, хөдөлмөрийн гэрээ зөрчсөн, эрхэлсэн ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн буюу зохих ёсоор биелүүлээгүй ажилтанд Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу сахилгын дор дурдсан шийтгэлийг Захирлын тушаалаар ноогдуулна:
- (a) амаар, эсхүл бичгээр сануулах,
 - (b) үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар, 20 хүртэл хувиар буруулах,
 - (c) ажлаас халах.
- 9.2 Энэхүү журамд заасан хөдөлмөрийн сахилгын ноцтой зөрчлүүд нь ажилтныг ажлаас шууд халах нөхцөл болно.
- 9.3 Энэхүү журмыг зөрчиж ажил тасалсан ажилтны ажиллаагүй цаг, өдөрт ноогдох суутгалыг түүний үндсэн цалингаас хасаж тооцно.
- 9.4 Ажилтанд сахилгын арга хэмжээ ноогдуулсан буюу сахилгын шийтгэлтэйд тооцогдох хугацаанд энэ журамд заасан ажлын үр дүнгийн шагнал олгохгүй. Сахилгын шийтгэлтэйд тооцогдох хугацаа 1 /нэг/ жил байна.

- 9.5 Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Төвд хохирол учруулсан ажилтанд холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу эд хөрөнгийн хязгаарлагдмал болон бүрэн хариуцлага хүлээлгэнэ.
- 9.6 Хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргаж ажлаас халагдсан хүнийг ажилд буцаан авахгүй.
10. **Татвар ба даатгал**
- 10.1 Төв нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтны сарын цалингаас хувь хүний орлогын албан татвар, ажилтны нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хэмжээгээр суутгаж харьяалах татварын алба, нийгмийн даатгалын санд шилжүүлнэ.
- 10.2 Төв нь хөлсөөр ажиллагчийн болон үйлчилгээ үзүүлэх гэрээгээр ажиллаж буй ажиллагчийн нийт цалин хөлсний холбогдох хувийг, хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу суутган авч харьяалах татварын албанд шилжүүлнэ.
- 10.3 Төв үйл ажиллагааны хүрээнд буюу үйл ажиллагаатай холбоотойгоор ямар нэгэн сургаалтанд хамрагдсан сургалтын төлбөрийг Төв төлсөн тохиолдолд нийт төлбөрийн зохих хувийг Ажилтан төлөх эсэхийг Ажил олгогч тухай бүрд нь шийдвэрлэнэ.
11. **Ажлын шаардлагаар ажилтны гаргасан зардал**
- 11.1 Ажлын зайлшгүй шаардлагаар ажилтан зардал гаргах тохиолдолд бэлэн мөнгө буюу урьдчилгааг санхүүгийн ажилтнаас ба их хэмжээний мөнгийг Захирлын зөвшөөрлөөр гаргуулна. Их хэмжээний мөнгөний хэмжээг Захирал тогтооно.
- 11.2 Томилолтын урьдчилгаа авсан тохиолдолд зардлыг тайлагнаж маягт бөглөн, төлбөрийн баримтыг хавсаргаж Харилцагчийн нягтлан бодогчид болон хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтанд өгч хянуулснаар дараачийн урьдчилгааг авах эрх нь нээгдэнэ.
- 11.3 Томилолтын урьдчилгаа гэдэгт зөвхөн тухайн ажилтны хөдөө орон нутагт эсвэл гадаад улсад байгаа байгууллагуудад томилолтоор ажиллах болон хурал зөвлөгөөн, уулзалт, яармагт оролцох, туршлага судлах, Төвийн үйл ажиллагааны чиглэлийн дагуу зохиогдож буй хичээл сургалтанд хамрагдах зэрэг ажлаар гадаад улсад явагчдын албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын ойлгоно.
- 11.4 Томилолтын урьдчилгаанд тухайн явагчийн хувийн нь илүү ачаа тээшний үнэ орохгүй болно. Харин Төвийн үйл ажиллагааны шаардлагаар зайлшгүй тээвэрлэх болсон ачаа тээшний зардлын Төв хариуцна.
- 11.5 Томилолтын урьдчилгаанд зөвхөн томилолтоор ажиллах болон хурал зөвлөгөөн, уулзалт, яармагт оролцох, туршлага судлах зорилгоор явж байгаа тохиолдолд Төвийг илэрхийлсэн, сурталчилсан лого бүхий бэлэг дурсгалын зүйлийн зардал багтаж болно.
- 11.6 Таксигаар үйлчлүүлэх төлбөрийн зөвшөөрлийг урьдчилан аваагүй тохиолдолд Төв нөхөн төлөхгүй.
12. **Хөдөлмөрийн дотоод журмын нарийвчилсан зарим зохицуулалт**
- 12.1 Ажилтан болон Төвийн эрх бүхий албан тушаалтныг сонгон шалгаруулах журам, Ажилчдын ёс зүйн дүрэм, сахилгын журам, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам, хүний нөөцийн бодлого, ажил, албан тушаалын жагсаалт, Төвийн байранд байрлах журам, үүрэн утас ашиглах журам, цагийн бүртгэл, ажлын үр дүнг тооцох журам, тамхины хэрэглээг хязгаарлах журам, жендерийн эрх тэгш байдлыг хангах журам, Төвийн удирдлагын албан тушаалтныг сонгон шалгаруулах гэх зэрэг бусад нарийвчилсан дүрэм,


журам, зохих маягтыг Хөдөлмөрийн дотоод журмын хавсралтаар баталж болно. Энэхүү журмын нэмэлт, өөрчлөлт болон журмын нэмэлт хавсралтыг ажилтнуудад танилцуулна.

- 12.2 Төвийн мэдээлэл, технологийн хэрэгсэл, сүлжээ ашиглах журам, Үүрэн утас хэрэглэх журмыг ажил олгогч баталж мөрдүүлж болно. Төвөөс олгосон үүрэн утас, утасны дугаар, цахим, мэдээлэл технологийн хэрэгсэл Төвийн өмч байна.
- 12.3 Төвийн аливаа албан тушаалтан, ажилтан жендерийн талаар өөрсдийн үүргээ заавал биелүүлэх, хүнийг хүйсээр болон арьс өнгө, бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүй, дарамтлахгүй байх ёстой бөгөөд ялгаварлан дарамтлах харьцаа хандлагыг үл тэвчих бодлогыг баримтална.

13. Бусад

- 13.1 Гэрээгээр үйлчилгээ үзүүлэх буюу хөлсөөр ажиллах хөлсөөр ажиллагчийн ажлын хөлсийг төлөх хуваарийг хөлсөөр ажиллагчтай байгуулах гэрээгээр зохицуулна. Гэрээгээр үйлчилгээ үзүүлэх буюу хөлсөөр ажиллах ажиллагчид илүү цаг ажилласан хугацааны хөлс төлөхгүй. Хөлсөөр ажиллах гэрээнд Хөдөлмөрийн дотоод журмын бусад нөхцөл, заалт үйлчлэхгүй бөгөөд хөлсөөр ажиллах асуудлыг Иргэний хууль болон хөлсөөр ажиллах гэрээгээр зохицуулна. Хөлсөөр ажиллагч нь Төвийн үндсэн ажилтан биш болно.
- 13.2 Хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулаагүй хөдөлмөрийн бусад харилцааг ажилтнуудтай байгуулах хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна.
- 13.3 Хөдөлмөрийн дотоод журам нь “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв”-ийн Захирлын баталснаар хүчин төгөлдөр болно.

-----o0o-----



Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн захирлын тушаалыг 12 сарын 22-ны өдрийн 1/22 тушаалын 2-р хавсралт

АЖИЛТНЫ НОТОЛГОО

Ажилтан _____ би “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв”-ийн Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм журамтай танилцаж ойлгосон, цаашид ажилдаа эдгээрийг даган мөрдөхөө ойлгож хүлээн зөвшөөрсөн болно.

Миний гарын үсэг зурагдсан энэхүү нотолгоог миний хувийн хэрэгт хадгална гэдгийг ойлгосон болно.

Энэхүү дотоод журмыг ямар нэгэн байдлаар даган мөрдөөгүй байдал нь сахилгын шийтгэлд, бусад болон хууль зүйн үр дагаварт хүргэж болохыг ойлгосон бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

Ажилтны нэр

Гарын үсэг

Регистрийн дугаар

Он, сар, өдөр

**CLIMATE CHANGE RESEARCH AND
COOPERATION CENTRE**

INTERNAL LABOR PROCEDURES

Ulaanbaatar
2023

**INTERNAL LABOR PROCEDURES OF THE
"CLIMATE CHANGE RESEARCH AND
COOPERATION CENTRE"**

1. General conditions

- 1.1 The internal labor regulations of "Climate Change Research and Cooperation Centre" ("CCRCC" or "**Employer**") are based on international agreements of Mongolia, the Constitution of Mongolia, Civil Law, Company Law, Labor Law, Law on Labor Safety and Hygiene, Law on State and Local Property, Law on Ensuring Gender Equality, Law on Environmental Protection, and are designed to uphold labor discipline and order among employees in alignment with international agreements, CCRCC's rules and regulations, and other pertinent laws. This document serves to govern labor relations related to optimizing time management, ensuring work efficiency, and delineating the rights, duties, and responsibilities of both the CCRCC and its employees.
- 1.2 The employer shall issue and enforce this internal procedure in accordance with the law, within the scope of the rights specified in the Labor Law, as it may be amended from time to time.
- 1.3 Every employee is responsible for adhering to labor discipline, working honestly and productively in accordance with this internal process, and fulfilling any other requirements imposed by applicable laws and regulations.
